

Түгээмэл асуултууд

“ABU Robocon 2019 Улаанбаатар”

2018.10.26

Дүрмийн номыг анхааралтай уншина уу. Хамтран ажилласанд баярлалаа.

Ангилал	Хүснэгтийн агуулга
0.	Нэр томьёо, тодорхойлолт
1.	Тоглоомын үйл явц ба тэмцээний даалгаварууд
1.1	Цаг тохируулах
1.2	Робот болон багийн гишүүдийн байрлал
1.3	Гэрэгэ болон Шагай
1.4	Хангайн бүсийн даалгавар
1.5	Гэрэгэ дамжуулах
1.6	Говийн бүсийн даалгавар
1.7	Шагай орхих
1.8	Уул руу авирах
2.	Дахин оролдлого
3.	Ялагчийг тодруулах
4.	Роботууд
5,6	Маргаан ба хасалт
7,8	Аюулгүй байдал ба багууд
9.	Бусад

Нэр томъёо ба тодорхойлолт

2018.10.26

0-1) Дүрмийн номны 8-р хуудсанд заагдсан "Нэр томъёо, тодорхойлолт", Элч-Робот 2 хөвөх боломжтой юу?

Хариулт: Элч-Робот 2-ыг хөвөх буюу нисэхийг зөвшөөрөхгүй.

0-2) Хэрэв нэг эд анги нь механикаар хоёр буюу түүнээс дээш хэсэг нь газартай хүрэлцэж байх бол үүнийг нэг хөлөнд тооцох уу? Жишээ нь: өндөр өсгийтэй эсвэл гета (Японы уламжлалт модон гутал).

Хариулт: Үүнийг нэг хөлд тооцож болно. Гэхдээ Элч-Робот 2 нь үзэгчдийн зүгээс харахад дөрвөн хөлөөрөө хөдөлдөг байхаар бүтээнэ үү. Нарийндаа бол уг робот нь 4 хөл тус бүр бие даан хөдөлдөг байх ба 4 хөлт амьтан шиг байхаар бүтээнэ.

0-3) Элч-Робот 2 нь хашлага эсвэл тоглоомын талбайн газар хэсэгт 4 хөлнөөс бусад хэсгээр хүрч болох уу? Жишээлбэл: Хашлаганд хүрэхээсээ өмнө зайгаа мэдрэх, робот маань унах үедээ хөлнөөс бусад хэсгээр газарт хүрэх гэх зэргээр мэдэрч ажиллаж болох эсэх?

Хариулт: Элч роботын хувьд зөвхөн дөрвөн хөлөө ашиглах ёстой. Үүнээс бусад хэсэг болон тав дахь хөл зэргийг ашиглахыг зөвшөөрдөггүй. Гэсэн хэдий ч хашлаганд л зөвхөн хүрэхийг зөвшөөрсөн байгаа.

0-4) Элч робот 2 нь морь шиг явдаггүй бол зөрчилд тооцох уу?

Хариулт: Элч-Робот 2 морь алхах механизм шиг байх шаардлагагүй.

0-5) Дүрмийн номоор бол хөлний механизм нь хөл дээрээ 360 градус эргэлддэг байхыг хориглодог гэхдээ хөлийг холбоос эсвэл түлхэх бүлүүрт механизм зэргийг ашиглан 360 градус эргүүлэх эргэлт хийхийг зөвшөөрөх үү? Мөн роботоо 360 градус эргэх боломж бүхий холбоосыг ашиглаж болох эсэхийг бидэнд мэдэгдээрэй.

Хариулт: 360 градусын эргэлтийн механизмыг ашиглан хөл эргүүлэхийн зөвшөөрнө.

0-6) Дөрвөн хөлнөөс бусад жолоодох хүчийг хэрэглэх боломжтой юу? Ялангуяа сэнстэй тийрэлтэт хөдөлгүүр гэх мэт зүйлс?

Хариулт: Дөрвөн хөлөөс бусад жолооны хүч ашиглахыг зөвшөөрөхгүй.

0-7) Элч-Робот 2 шилжилтийг хийх үедээ дөрвөн хөл нь газарт харьцахдаа алхалтын нэг циклт байх шаардлагатай юу?

Хариулт: Алхалтын нэг цикли нь дөрвөн хөл тус бүрийг газартай харьцсан байх ба салангад хөдөлгөөн. Нэг цикли гэдэг нь 4 хөлөөр хөдөлгөөн хийх үеийн давтамж хөдөлгөөнийг хэлдэг. Та элсэн манханг гатлах үед нэг хөл ашиглах боломжгүй.

0-8) Элч-Робот 2 хөдөлгөөн хийх үедээ сэгсрэх болон хөл чирэх үйлдэл хийхийг зөвшөөрөх үү? Дэлгэрэнгүй тайлбар өгнө үү?

Хариулт: Талбайд хөл өргөхгүйгээр чирэх хөдөлгөөн хийхийг хориглоно. Харин хөлийг газраас өргөх буулгах үеийн богино хугацааны чирэх үйлдлийг зөвшөөрнө.

0-9) Элч-Робот 2-ын бүх хөлийг талбайгаас нэг зэрэг гаргахаар зөвшөөрсөн үү?

Хариулт: Тийм зөвшөөрнө. Хэрвээ Элч-Робот 2 бусад хэсэг нь тоглоомын талбарт хүрсэн бол энэ нь зөрчил болох ба, баг дахин оролдохыг асууж болно.

0-10) Элч-Робот 2-ын тавдугаар хэсэг тод шар бүстэй хэсэгт хүрвэл юу гэж үзэх вэ?

Хариулт: Хэрэв Элч-Робот 2 -ын 4 хөлнөөс бусад хэсэг тоглоомын талбарт хүрвэл энэ нь зөрчил болно.

2018.12.10

0-11) Түгээмэл асуултууд дугаар (0 – 7) д байснаар Элч-Робот 2 ын бүх хөл газартай харьцсан байх үедээ чиглэлээ өөрчлөхийг зөвшөөрөх үү?

Хариулт: Тийм, зөвшөөрнө.

0-12) Түгээмэл асуултууд дугаар 1 ээр бол алхалтын нэг циклид 4 хөл газартай харьцсан байх ёстой гэсэн. Хэрэв робот нь чиглэлээ өөрчлөхийн тулд аль нэг тодорхой хөлөө ашиглан тэнхлэгээрээ эргэх тохиолдолд дүрмээр энэ нь зөрчил болох үү?

Хариулт: Үгүй, энэ нь дүрэмтэй зөрчилдөхгүй. Алхах шаардлага нь алхахад зориулсан нөхцөл ба энэ нь тоглоомын туршид үргэлж байх ёстой дүрэм биш.

0-12) Элч-Робот 2 нь олс давах үйлдэл хийх үед 4 хөлнөөс бусад хэсгээр олсонд хүрэхийг зөвшөөрөх үү?

Хариулт: Элч-Робот 2 нь 4 хөлнөөс бусад хэсгүүдээр олсон хүрэх боломжтой боловч Элч-Робот 2 ын даралтаас болж олс гэмтэж тасарсан тохиолдолд танай баг тоглоомонд ялагдал хүлээнэ.